

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/043/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор: О.Энхтөр

Утас: 95343496 Цахим хаяг: oturuu87@gmail.com

Аудитор: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/043/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.24 № 07

танай _____ -ны № _____ -т

ЦОГТ СУМЫН БАЯНТООРОЙ
ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Б.БАЯРБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8225020244

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8,893.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, аймгийн ИТХ-ын тогтоолоор 266,529.1 мянган төгрөгийн Эрүүл мэндийн барилгыг шилжүүлэн авч хөрөнгөд бүртгэн, улсын төсвийн хөрөнгөөр 199,900.0 мянган төгрөгийн автомашин, орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээс 64,000.0 мянган төгрөгийн худгийг хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор хөрөнгөд бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 хөтөлбөр, 7 зорилт, 78 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж биелэлтийн тайланг хүргүүлснээс сумын Засаг даргаас нийт дүнгээр 84.2 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,921,200.00	46,172,570.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	7,511,406.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	7,511,406.00
3121	Төгрөг	-	7,511,406.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	7,511,406.00
33	АВЛАГА	25,000,000.00	17,520,464.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	31,870.00
335	Бусад авлага	25,000,000.00	17,488,594.00
3351	Байгууллагаас авах авлага	25,000,000.00	17,488,594.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,921,200.00	21,140,700.00
354	Хангамжийн материал	25,921,200.00	21,140,700.00
35410	Бичиг хэргийн материал	700,600.00	515,100.00
35420	Аж ахуйн материал	7,902,100.00	7,902,100.00
35440	Түлш, шатах тослох материал	10,437,500.00	5,708,000.00
35450	Барилгын засварын материал	50,000.00	50,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,831,000.00	6,965,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	457,252,943.39	899,184,522.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	457,252,943.39	899,184,522.86
392	Биет хөрөнгө	442,356,943.39	884,288,522.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	282,055,659.56	548,584,823.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,755,849.02)	(92,048,630.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,700,000.00	232,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,485,000.08)	(33,083,333.42)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,018,800.00	24,396,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,107,745.77)	(9,361,737.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,538,000.00	3,645,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,124,667.44)	(2,559,793.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	241,067,450.00	305,067,450.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(61,549,703.86)	(92,952,056.72)
393	Биет бус хөрөнгө	14,896,000.00	14,896,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,896,000.00	14,896,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	508,174,143.39	945,357,092.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	673,643.00	96,306.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	673,643.00	96,306.00
413	Өглөг	673,643.00	96,306.00
41310	Ажилчидтай хэлбогдсон өглөг	673,643.00	
41360	Бусад өглөг		96,306.00
41363	Татварын өглөг		96,306.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	507,500,500.39	945,260,786.86
51	Засгийн газрын хувь оролцоо	507,500,500.39	945,260,786.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,632,979.09	44,632,979.09
51101	Өмч: - төрийн	44,632,979.09	44,632,979.09
512	Хуримтлагдсан үр дүн	232,455,584.58	670,215,871.05
51210	Өмнөх үеийн үр дүн	232,455,584.58	232,455,584.58
51220	Тайлант үеийн үр дүн		437,760,286.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,411,936.72	230,411,936.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	508,174,143.39	945,357,092.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	301,348,400.00	793,141,184.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,520,000.00	502,840,384.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,520,000.00	502,840,384.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,520,000.00	502,840,384.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	720,000.00	240,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,800,000.00	502,600,384.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	280,828,400.00	290,300,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,960,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,960,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,868,400.00	290,300,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226,868,400.00	290,300,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	278,440,940.89	355,380,897.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,440,940.89	355,380,897.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,915,930.39	346,004,528.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,841,794.44	175,250,317.78
210101	Үндсэн цалин	90,399,411.65	117,609,698.52
210102	Нэмэгдэл	18,235,436.59	51,152,619.26
210104	Урамшуулал	6,206,946.20	6,488,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,069,315.15	22,480,023.00
210201	Тэтгэврийн даатгал	10,943,523.07	15,840,023.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,038,982.33	1,660,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	831,226.36	830,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	204,353.49	830,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,051,229.90	3,320,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,875,190.91	35,498,167.44
210301	Гэрэл, цахилгаан	783,190.91	1,088,667.44
210302	Түлш, халаалт	14,092,000.00	34,409,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,938,565.00	34,493,120.00
210401	Бичиг хэрэг	1,194,250.00	1,385,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,265,940.00	30,499,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	896,900.00	599,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	532,225.00	583,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,049,250.00	1,425,500.00
2105	Нормативт зардал	793,600.00	360,000.00
210502	Хоол, хүнс	793,600.00	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,700,000.00	3,496,000.00
210604	Урсгал засвар	2,700,000.00	3,496,000.00
2107	Томилолт, зочны зардал	792,000.00	986,000.00
210702	Дотоод албан томилолт	792,000.00	986,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,275,217.00	1,014,096.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,156,750.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,716.00	47,686.00
210807	Газрын төлбөр	76,751.00	66,410.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,630,247.89	72,426,804.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,499,600.00	2,865,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,130,647.89	69,561,804.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,525,010.50	9,376,368.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,570,200.00	2,490,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,920,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,650,000.00	2,490,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,954,810.50	6,886,368.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,954,810.50	6,886,368.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	22,907,459.11	437,760,286.47
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	22,907,459.11	437,760,286.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	281,548,400.00	315,540,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	720,000.00	240,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	720,000.00	240,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	720,000.00	240,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	720,000.00	240,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	280,828,400.00	315,300,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,960,000.00	25,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,960,000.00	25,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,868,400.00	290,300,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226,868,400.00	290,300,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	254,408,600.00	299,136,394.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,408,600.00	299,136,394.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,883,589.50	289,760,025.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,168,151.44	176,088,747.78
210101	Үндсэн цалин	89,725,768.65	116,112,992.76
210102	Нэмэгдэл	18,235,436.59	51,152,619.26
210104	Урамшуулал	6,206,946.20	8,823,135.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,069,315.15	22,250,800.00
210201	Тэтгэврийн даатгал	10,943,523.17	15,610,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,038,982.33	1,660,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	831,226.36	830,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	204,353.39	830,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,051,229.90	3,320,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,270,690.91	30,768,667.44
210301	Гэрэл, цахилгаан	783,190.91	1,088,667.44
210302	Түлш, халаалт	19,487,500.00	29,680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,142,015.00	34,442,120.00
210401	Бичиг хэрэг	1,249,700.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,965,940.00	30,499,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	896,900.00	599,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	532,225.00	583,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,497,250.00	1,560,000.00
2105	Нормативт зардал	793,600.00	360,000.00
210502	Хоол, хүнс	793,600.00	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,750,000.00	3,496,000.00
210604	Урсгал засвар	2,750,000.00	3,496,000.00
2107	Томилолт, зочны зардал	792,000.00	986,000.00
210702	Дотоод албан томилолт	792,000.00	986,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,635,217.00	18,502,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,516,750.00	18,388,594.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,716.00	47,686.00
210807	Газрын төлбөр	76,751.00	66,410.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,262,600.00	2,865,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800,000.00	2,865,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	462,600.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,525,010.50	9,376,368.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,570,200.00	2,490,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,920,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,650,000.00	2,490,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,954,810.50	6,886,368.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,954,810.50	6,886,368.78
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг-нэмэлт	25,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,139,800.00	16,404,406.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,139,800.00	8,893,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,139,800.00	8,893,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,139,800.00	8,893,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,139,800.00	8,893,000.00

Цогт сумын Баянтоорой тосгоны захирагчийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(27,139,800.00)</u>	<u>(8,893,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	7,511,406.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,511,406.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023.01.01-ний үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	209,548,125.47	484,593,041.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	209,548,125.47	484,593,041.28
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	22,907,459.11	22,907,459.11
C08	2023.12.31-ний үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	232,455,584.58	207,455,584.58
D01	2024.01.01-ний үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	232,455,584.58	482,500,500.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	232,455,584.58	507,500,500.39
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	437,760,286.47	437,760,286.47
D09	2024.12.31-ний үлдэгдэл	44,632,979.09	230,411,936.72	670,215,871.05	945,260,786.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	290,300,800.00	283,654,431.22	6,646,368.78	97.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290,300,800.00	283,654,431.22	6,646,368.78	97.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	287,800,800.00	281,164,431.22	6,636,368.78	97.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,000,000.00	176,088,747.78	1,911,252.22	98.93
210101	Үндсэн цалин	114,000,000.00	116,112,992.76	-	101.85
				2,112,992.76	
210102	Нэмэгдэл	50,400,000.00	51,152,619.26	-752,619.26	101.49
210104	Урамшуулал	13,600,000.00	8,823,135.76	4,776,864.24	64.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,250,800.00	22,250,800.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	15,610,800.00	15,610,800.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,660,000.00	1,660,000.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	830,000.00	830,000.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	830,000.00	830,000.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,320,000.00	3,320,000.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,252,000.00	30,768,667.44	483,332.56	98.45
210301	Гэрэл, цахилгаан	1,182,000.00	1,088,667.44	93,332.56	92.10
210302	Түлш, халаалт	30,070,000.00	29,680,000.00	390,000.00	98.70
2104	Хангамж, бараа материалын зардал	34,443,000.00	34,442,120.00	880.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	30,500,000.00	30,499,220.00	780.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	599,900.00	100.00	99.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	583,000.00	583,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,560,000.00	1,560,000.00	0.00	100.00
2105	Норматив зардал	360,000.00	360,000.00	0.00	100.00
210502	Хоол, хунс	360,000.00	360,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,500,000.00	12,389,000.00	3,111,000.00	79.93
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500,000.00	8,498,000.00	3,002,000.00	73.90
210602	Тавилга	500,000.00	395,000.00	105,000.00	79.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,496,000.00	4,000.00	99.89
2107	Томилолт, зочны зардал	1,200,000.00	986,000.00	214,000.00	82.17
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	986,000.00	214,000.00	82.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,095,000.00	1,014,096.00	80,904.00	92.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900,000.00	900,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,000.00	47,686.00	77,314.00	38.15
210807	Газрын төлбөр	70,000.00	66,410.00	3,590.00	94.87

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 10,203.3 мянган төгрөгийн 3 алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

• Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Санхүүгийн тайланд Татварын хэлтэст ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ыг 96.3 мянган төгрөгөөр дутуу шилжүүлж тайланд өглөгөөр тайлагнаагүй,
- Нутгийн Оргил грудд ХХК-тай нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг 25.0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулан тайлант онд 17,488.6 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн, ажлыг эхлээгүй байхад нягтлан бодогч үлдэгдэл санхүүжилт 7,511.4 мянган төгрөгийг өглөгөөр тусгасан,
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 261.1 мянган төгрөгийг зөрүүтэй тайлагнасан,
- Урамшуулалт цалинг 2,334.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 17,488.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 26,936.6 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрч 950.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 8,498.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгуулах албан шаардлага, 17,488.6 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

Төлбөрийн акт

Юмт хайрхан ХХК-д газрын алим худалдан авахад 750.0 мянган төгрөг, Алаг Энгэсэг ХХК-д караоке төхөөрөмжийн түрээсийн хөлсөнд 200.0 мянган төгрөгийг шилжүүлж төсвийг зориулалт бус төлөвлөгдөөгүй арга хэмжээнд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалттай нийцэхгүй үнэн зөв, бодитой, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

Цахим дэлгүүрээс 8,498.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байж, биелэлтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Нутгийн Оргил групп ХХК-тай нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг 25,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж, 17,488.6 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг гэрээний дагуу олгосон ч ажлыг эхлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т "төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх" заалттай нийцэхгүй үнэн зөв, бодитой, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийг хуулийн байгууллагад хандах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлэе.

Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянтоорой тосгоны ЗА	3	10,203.3	1	96.3	2	10,107.0	3	10,203.3				
Дүн	3	10,203.3	1	96.3	2	10,107.0	3	10,203.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Баянтоорой тосгоны ЗА	1	9,448.0	1	950.0	1	8,498.0					-	-		
Дүн	1	9,448.0	1	950.0	1	8,498.0					-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баянтоорой тосгоны ЗА								
Дүн			-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Баянтоорой тосгоны ЗА	1	17,1488.6	-	-	-	-	1	17,1488.6
Дүн	1	17,1488.6			-	-	1	17,1488.6
-Нийт дүн	1	17,1488.6			-	-	1	17,1488.6

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй	7	8				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

-----oOo-----